



**ШИНЖЛЭХ УХААН
ТЕХНОЛОГИЙН САНГИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2019 оны 09 сарын 27 өдөр

Дугаар A/33

Улаанбаатар хот

**Байгууллагын стратеги төлөвлөгөөг
батлах тухай**

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заал, Шинжлэх ухаан, технологийн сангийн дүрмийн 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Шинжлэх ухаан, технологийн сангийн 2019-2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, хөгжлийн хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

Байгууллагын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг мөрдөж ажиллахыг нийт ажилтан, албан хаагчдад үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



М.ТУНГАЛАГ

Шинжлэх ухаан технологийн сангийн
захирлын 2019 оны 24 дугаар сарын
... өдрийн 133 дугаар тушаалын
хавсралт



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ, ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР (2019-2025)

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Оршил

Засгийн газрын Тусгай сан Шинжлэх ухаан, технологийн сан (цаашид "сан" гэх)-гийн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, хөгжлийн хөтөлбөр /цаашид "хөтөлбөр" гэх)-ийн зорилго нь Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээнд Монгол улсын шинжлэх ухаан, технологийн салбарын санхүүгийн удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгож, үр дүнд суурилсан инноваци, технологи, үйлдвэрлэлийг хөгжүүлж, шинжлэх ухааны үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх санхүүгийн сахилга батыг нэмэгдүүлэх, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зэрэг асуудлыг хамарсан стратеги төлөвлөгөө болон хөгжлийн хөтөлбөрийг загварыг тодорхойлоход оршино.

1.2. Үндэслэл

Энэхүү хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Монгол улсын Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Инновацийн тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын 1998 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 55 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай" бодлогын баримт бичиг, холбогдох бусад хууль тогтоомжуудыг тус тус үндэслэн боловсруулав.

1.3 Хууль, эрхзүйн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ.

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Монгол Улсын Төрийн албаны тухай хууль;
- Засгийн газрын Тусгай сангийн тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;

- Шинжлэх ухаан, технологийн тухай хууль;
- Инновацийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Бусад хууль тогтоомж

1.4 Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахдаа олон улсын зөвлөмж, гадаад орнуудын байгууллагын өөрчлөлтийн удирдлага, үйл ажиллагааны төлөвлөлт болон Засгийн газар, яам, агентлаг, тусгай сангуудын үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, хөгжлийн хөтөлбөрийг загваруудыг ашиглав.


1.5 Сангийн үүрэг, хариуцлагын ерөнхий хуваарь

Сан нь Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны Шинжлэх ухаан, технологийн санхүүжилт, үр дүнд суурилсан санхүүгийн хяналтын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх түүний үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, санхүүжүүлэх, зарцуулсан хөрөнгийн ашиглалтад хяналт тавих, нэгтгэн тайлагнах үндсэн чиг үүрэг бүхий байгууллага бөгөөд Монгол Улсын БСШУС-ын сайдад зөвлөх, бүх талын дэмжлэг үзүүлнэ. Сан нь шинжлэх ухаан, технологийн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан уялдаа холбоог хангах асуудалд хууль тогтоомжийн хүрээнд өргөн хүрээтэй хандаж, зөв зохистой удирдаж зохицуулна.

Сан нь Шинжлэх ухаан, технологи, инноваци, өндөр технологийн үйлдвэрлэлийн салбарын санхүүгийн бодлого, хяналт тавих олон улсын жишигт нийцүүлэх, Монгол Улсын мэдлэгийн эдийн засгийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн экспортыг дэмжсэн үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үндсэн чиг үүргийнхээ хүрээнд чанартай, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх зэрэг асуудлыг хамарсан шинжлэх ухаанч үүрэг, хариуцлага хүлээнэ.

1.6 Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Сангийн стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэрийг оновчтой, бүрэн тодорхойлох нь сангийн үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой. Энэ хэрэгцээний эх үүсвэрт дараах загварт оруулсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч багтана.



Сангийн стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Шинжлэх ухааны салбарын хүрээлэн төв, корпораци, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, БСШУС-ын сайдын багцад хамаарах төрийн үйлчилгээний байгууллага, захиалагч яам, агентлаг, эрдэмтэд, иргэд байна.

Сангийн стратегийн удирдлага зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад чиглэнэ.

Сангийн стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр бүрээр тогтоон тус Сангийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, төрийн албан хаагчдын ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод тусгаж хэрэгжүүлнэ.

ХОЁР. ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1 Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Сангийн үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагаа, шинжлэх ухаан, технологийн хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, цөм технологи болон Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Шинжлэх ухаан, технологийн санхүүжилт, үр дүнд суурилсан санхүүгийн хяналтын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх түүний үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, санхүүжүүлэх, зарцуулсан хөрөнгийн ашиглалтад хяналт тавих, нэгтгэн тайлагнах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2 Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Сан нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

2.2.1 Монгол улсын үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинг хамгаалах, үндэсний үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний өрсөлдөх чадварыг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах дээшлүүлэхэд Шинжлэх ухаан, технологийн санхүүжилт, саихүүгийн үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэх;

2.2.2 Нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинжлэх ухаанч байдлыг хангах үр дүнд суурилсан санхүүжилтийн бодлогоор дэмжих, Монгол Улсын Шинжлэх ухааны салбарын санхүүжилтийн тогтолцоо, эрдэм шинжилгээний хүрээлэн, төвүүдийн хууль эрхийн санхүүгийн чадавхийг нэмэгдүүлж олон улсын түвшинд хүргэх;

2.2.3 Олон улсын шаардлагад нийцсэн Шинжлэх ухаан, технологийн санхүүжилт, үр дүнд суурилсан эрдэм шинжилгээний байгууллагын тогтолцоог бий болгох, эдийн засгийн чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.2.4 Эрдэм шинжилгээний байгууллага, хүрээлэн, төвүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээний болон удирдлагын тогтолцоог сайжруулж худалдаа, үйлчилгээ, Инновацийн үйлдвэрлэл, гарааны компаниудыг дэмжих, тэдэнд зах зээл дээр шударга өрсөлдөх таатай нөхцлийг бүрдүүлэх;

2.2.5 Эрдэм шинжилгээний ажлын үр дүнгийн баталгааг олон улсын түвшинд хүргэх, эрдэмтдийн чансааг тодорхойлох үйлчилгээг олон улсын стандартын дагуу хийж эрдэмтэн, судлаачдын эрх ашгийг хамгаалах;

2.2.6 Шинжлэх ухаан, технологийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр хэрэгжсэн судалгаа шинжилгээний үр дүн, технологийг эдийн засгийн эргэлтэнд

оруулах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, эрдэм шинжилгээний байгууллагуудын дэргэд гарааны компаниудыг байгуулах, сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн уялдааг сайжруулах, их сургуулиудыг судалгаанд суурилсан их сургууль болгон хөгжүүлэх;

2.2.7 Эрдэм шинжилгээний байгууллагуудыг хувийн хэвшилтэй холбох, хүний нөөцийн чадавхийг сайжруулах, улс орны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн мэдлэгт суурилсан эдийн засгийг хөгжүүлэх, нийтлэг арга зүйгээр хангах, үндэсний итгэмжлэгдсэн дундын лабораториудын тогтолцоог бий болгох, мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах, бүс нутгийн болон олон улсын лабораторийн хамтын ажиллагааг өргөжүүлэх,

2.3 Үйл ажиллагааны зарчим

Сангийн үйл ажиллагааны үндсэн зарчим нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим, Монгол улсын Авлигын эсрэг хуулийн 6-р зүйлийн 1 дэх хэсгийн 3, 4, 5, 6, 7, 10, 11 дахь хэсэгт заасан үүрэг хүлээх, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 5 дахь зүйлийн үндсэн зарчим, Төрийн албаны тухай хуулийн 4 зүйлийн 2 дахь хэсгийн үндсэн зарчим, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5 зүйлийн 1 дэх хэсгийн үндсэн зарчим, Төсвийн гухай хуулийн 5,6 зүйлийн үндсэн зарчим, 15 зүйлийн бүрэн эрх, 18, 19 зүйлийн нягтлан бодогч томилох, чөлөөлөх шаардлагын дагуу, Хөдөлмөрийн тухай хуулийн 4 зүйлийн Хөдөлмөрийн харилцааг зохицуулах зарчим, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 4 зүйлийн үйл ажиллагааны зарчим, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 20, 26, 28, 29, 30, 31 зүйлүүдэд заасны дагуу төрийн үйлчилгээг жигд, чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, хууль ёсыг сахих, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх зарчмыг баримтлах явдал мөн.

2.4 Үйл ажиллагааны эрхэм зорилго

Эрхэм зорилго: Монгол Улсын Хөгжлийн стратеги чиг хандлагад нийцүүлэн Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэхэд санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн улс орон, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг бэхжүүлэх, үр дүнд суурилсан эрдэм шинжилгээний байгууллагын тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

2.5 Үйл ажиллагааны стратегийн зорилт

Шинжлэх ухаан, технологийн сан нь эрхэм зорилгодоо хүрэхийн тулд дараахь стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ:

2.5.1 Төрийн үйлчилгээний байгууллагын удирдлагыг хангах, гадаад болон дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх;

2.5.2 Шинжлэх ухаан, технологийн санхүүжилт, үр дунд суурилсан эрдэм шинжилгээний байгууллагын нэгдмэл байдлыг хангах хууль тогтоомжийг боловсронгуй болгоход санал боловсруулах, бодлого стратегийг төлөвлөх, бодлогын удирдамжаар хангах хэрэгжилтийг зохицуулах;

2.5.3 Шинжлэх ухаан, технологийн зохицуулалтын хөтөлбөр, төсөл боловсруулах, төсөл шалгаруулах, санхүүжүүлэх зохицуулалтыг олон улсын жишгээр бий болгоход дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн төсөлд шүүлт хийх, санхүүжүүлэх чиглэлийн дүрэм журам, заавар, удирдамжаар хангах;

2.5.4 Эрдэм шинжилгээний байгууллагын тогтолцоо, санхүүгийн болон үр дүнгийн механизмыг олон улсын системд тулгуурласан үндэсний загвар тогтолцоог хөгжүүлэх, эрдэм шинжилгээний хүрээлэн төвийн дэргэдэх хамтын лабораториудын хэвийн ажиллагааг хангах, санал боловсруулах, хэрэгжүүлэх, санхүүгийн зохицуулалтыг хангах;

2.5.5 Судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг сайжруулах, үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх боломжоор хангах, төслийн явц, үр дүн, хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавих, мониторинг хийх, үнэлгээ шинжилгээ хийх, тайлагнах;

2.5.6 Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийн төслүүдийг дэмжин хөгжүүлэх, түүнийг нийгэм эдийн засгийн хүрээнд хэрэгжүүлэх, үр ашгийг нийтийн хүртээл болгоход санхүүгийн баталгаатай эх үүсвэрээр хангах, бүрдүүлэх, Шинжлэх ухаан, технологийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр хэрэгжсэн судалгаа шинжилгээний үр дүн, технологийг эдийн засгийн эргэлтэнд оруулах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх;

2.5.7 Эрдэм шинжилгээ, судалгаа боловсруулалтын ажлын тайлан, Эрдмийн зэрэг хамгаалсан диссертацийг фондлон хадгалж Монгол улсын Оюуны санг бүрдүүлэх, хамгаалах, сурталчилах, эдийн засгийн эргэлтэнд оруулах.

2.6 Үйл ажиллагааны гол зорилт

Шинжлэх ухаан, технологийн сангийн үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд дор дурьдсан үйл ажиллагааны гол зорилтыг дэвшүүлэн ажиллана:

2.6.1 Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

2.6.1.1 Төрийн үйлчилгээний байгууллагын удирдлагын манлайллыг хангах, хөрөнгө санхүүгийн удирдлага, дотоод үйлчилгээгээр байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

2.6.1.2 Салбарын санхүүгийн хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, гадаад хамтын ажиллагааны удирдлага, зохицуулалтад дэмжлэг үзүүлэх;

2.6.1.3 Хууль тогтоомжийн биелэлт, Сангийн захирлын шийдвэрийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;

2.6.2 Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.6.2.1 Шинжлэх ухаан, технологийн санхүүжилт, үр дүнд суурилсан эрдэм шинжилгээний байгууллагын нэгдмэл байдлыг хангах хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд саиал боловсруулж дээд шатны байгууллагад уламжлах;

2.6.2.2 Шинжлэх ухаан, технологийн санхүүжилт, үр дүнд суурилсан эрдэм шинжилгээний байгууллагын нэгдмэл байдлыг хангах бодлого, стратегийг төлөвлөх, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах, хэрэгжилтийг зохицуулах;

2.6.2.3 Салбарын эрх зүйн орчныг зохицуулах хууль тогтоомжтой нийцүүлэн холбогдох дүрэм, журмуудыг шинэчлэн сайжруулах санал боловсруулах;

2.6.3 Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

2.6.3.1 Шинжлэх ухаан, технологийн зохицуулалтын хөтөлбөр, төсөл боловсруулах, төсөл шалгаруулах, санхүүжүүлэх зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох;

2.6.3.2 Шинэ дэвшилтэт технологи үйлдвэрлэл, үйлчилгээг нэвтрүүлэхэд бодлогоор байнгын дэмжлэг туслалцаа үзүүлэх;

2.6.3.3 Олон улс, бүс нутаг, яам хоорондын шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, санхүүжүүлэх;

2.6.3.4 Төсөлд шүүлт хийх, санхүүжүүлэх чиглэлийн дүрэм журам, заавар удирдамжаар хангах, хяналт шинжилгээ хийх үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, арга зүйгээр хангах;

2.6.4 Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

2.6.4.1 Эрдэм шинжилгээний байгууллагын тогтолцоо, санхүүгийн механизм, үр дүнгийн механизмыг олон улсын системд тулгуурласан үндэсний загвар тогтолцоог хөгжүүлэх;

2.6.4.2 Эрдэм шинжилгээний байгууллага, лабораторид ашиглагдаж байгаа өндөр нарийвчлал бүхий хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, шалгалт тохируулгын тогтолцоог бий болгож сайжруулах арга хэмжээг авах, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны орчинг бүрдүүлэх, хамтарсан лабораторийн менежментийг зохион байгуулах;

2.6.4.3 Дундын лаборатори, судалгаа боловсруулалтын ажил, үйлчилгээний загварын туршилт хийх тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хялбаршуулах, боловсронгуй болгох, олон улсын түвшинд хүргэх, нэгж хүрээлэн төвүүдийн загвар тогтолцоог сайжруулан бэхжүүлэх, эрдэм шинжилгээний хүрээлэн төвүүдийн дэргэдэх хамтын лабораторийн хэвийн ажиллагааг хаигах, хэрэгжүүлэх, санхүүгийн зохицуулалтыг хангах;

2.6.5 Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд:

2.6.5.1 Шинжлэх ухаан, технологийн төслүүдийг зарлах, сонгон шалгаруулах ажилд оролцох, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийн эрдэм шинжилгээний судалгааны төсөлт ажил болон гадаад дотоодын хамтарсан төслүүдийг зарлах, санхүүжүүлэх;

2.6.5.2 Төслүүдэд санхүүгийн болон хөрөнгө оруулалтын шинжилгээ, эрсдлийн шинжилгээ хийх, мэргэжлийн экспертийн /хөндлөнгийн/ дүгнэлт гаргуулах, төслийн багийн /субъектэд/ ажлын агуулга нь оюуны өмчийн эрхийн холбогдох хууль тогтоомжийн хүрээнд байгаа эсэх, зөрчлийг арилгуулах, явцын болон үр дүнгийн тайланд мониторинг, үнэлгээ хийх, тайлагнах;

2.6.5.3 Гадаадын ижил төстэй сангууд, гадаад улс, байгууллагуудтай хамтран ажиллах, хамтарсан төслүүдийг шударга өрсөлдөөнийг дэмжих замаар нээлттэй ил тод зарлах, эдийн засгийн үр ашигтай төслүүдийг дэмжих замаар санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх;

2.6.5.4 Шинжлэх ухаан, технологийн санхүүжилтийн үйл ажиллагааны талаарх хэрэглэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх улмаар тэдэнд зөв сонголт хийх, өөрийн үйл ажиллагаанд итгэх итгэлийг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлэх;

2.6.6 Үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд:

2.6.6.1 Эрдэм шинжилгээний байгууллагын дундын лаборатори, эрдэмтдийг хөгжүүлэх тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр олон улсын төсөл, үндэсний хөтөлбөрийг боловсруулж санал оруулах, хэрэгжилтийн зохицуулалтыг хангах, санхүүгийн олон эх үүсвэрийг бүрдүүлэх;

2.6.6.2 Тухайн жилд төлөвлөгдсөн төсөвт ажлын эх үүсвэрийг Санд төсөвлөн батлуулах, төслийн анхан шатны баримт бичигтэй танилцаж, дүгнэлт гаргах;

2.6.6.3 Төслийн багтай гэрээ хийж хөрөнгө зардлыг хуваарилах, үе шаттайгаар санхүүжүүлэх, шинжлэх ухаан, технологийн арга хэмжээний дунд хугацааны санхүүгийн төлөвлөлтийг хийх, төслийг санхүүжүүлэхдээ хуульд заасны дагуу эргэн төлөгдөх нөхцөл буюу үр ашгийн зохих хувийг санд төвлөрүүлэх талаар гэрээнд тодорхой тусгаж санхүүжүүлэх;

2.6.6.4 Шинжлэх ухаан, технологийн төслүүдийн үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлсэний орлогоос сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх;

2.6.6 Үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын хүрээнд:

2.6.7.1 Эрдэм шинжилгээний тайлан, эрдэмтдийн бүтээлийг цахим болон хэвлэмэл хэлбэрээр оюуны санг бүрдүүлэн нэгтгэх, судалгаа хийх, хадгалах, оюуны сангийн мэдээллүүдийг төрөлжүүлэх, нэгдсэн баазыг баяжуулах, ашиглах оновчтой хувилбарыг бий болгох;

2.6.7.2 Баримт бичгийн санг байгуулах, чирэгдэлгүй хурдан шуурхай үйлчлэх, мэдээллүүдийг татаж авах боломжийг бүрдүүлэх, и-номын сан байгуулж, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, шинэ зарлал, мэдээллүүдийг цаг алдалгүй хүргэх;

2.6.7.3 Захиалагч яамдууд өөрсдийн хэрэгжүүлж буй төсөлд хяналт тавих, судалгаа хийх, дууссан төслүүдийн тайлангаар судалгаа хийж мэдээллээр хангах, эрдэмтэн судлаачдын судалгаа боловсруулалтын ажлын давхардлыг арилгах, байгууллага, иргэд судлаачдад мэдээлэл судалгаа боловсруулж өгөх;

2.6.7.4 Эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн судлаачдын гаргасан оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэнд оруулах, эрдэм шинжилгээний байгууллага болон Инкубатор байгуулан эрдэм шинжилгээний байгууллагуудын дэргэдэх гарааны компаниудыг дэмжих, эрдэм шинжилгээний байгууллагуудын гаргасан оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэнд оруулах, эрдэм шинжилгээний байгууллагуудыг хувийн хэвшилтэй холбох, энтрепренёршипыг хөгжүүлэх, Виртуал паркийг ажиллуулах;

2.7 Үйл ажиллагааны зорилт

Сангийн үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааны зорилт тус бүрийг тодорхойлж, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтод тусган хэрэгжүүлнэ.

2.8 Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө

Сангийн эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг боловсруулан баталж төсвийн ерөнхийлөн захирагч (БСШУС-ын сайд)-аас төсвийн шууд захирагч (Сангийн захирал)-тай байгуулах үр дүнгийн гэрээний салшгүй хэсэг байна.